

ГАДААДЫН ТӨРИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ ХҮСЭЛТИЙГ ХҮЛЭЭН АВЧ, ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмын зорилго нь Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заасан гадаадын төрийн өмчит хуулийн этгээд хөрөнгө оруулалт хийх зөвшөөрөл хүсэх, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Энэхүү журам нь гадаадын төрийн өмчит хуулийн этгээд уул уурхай, банк, санхүү, хэвлэл мэдээлэл, харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх Монгол Улсын хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 33 буюу түүнээс дээш хувийг шууд болон шууд бусаар эзэмших зорилгоор хөрөнгө оруулалт хийх тохиолдолд хамаарна.

1.3.Энэхүү журамд хэрэглэсэн нэр томъёог Хөрөнгө оруулалтын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан утгаар ойлгоно.

Хоёр.Зөвшөөрөл хүсэх, хүсэлтийг хүлээн авах

2.1.Зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээд хүсэлтээ Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д заасан баримт бичгийн хамт цаасан эсхүл цахим хэлбэрээр хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад шууд эсхүл Монгол Улс дахь төлөөлөгчийн газар, итгэмжлэгдсэн төлөөлөгчөөрөө дамжуулан гаргана.

2.2.Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүсэлтийг хүлээн авч бүртгэснээс хойш ажлын 2 өдрийн дотор баримт бичгийн бүрдлийг шалгана.

2.3.Хэрэв баримт бичгийн бүрдэл дутуу эсхүл бусад баримт бичиг шаардлагатай тохиолдолд энэ тухай хүсэлт гаргагчид бичгээр эсхүл цахим хэлбэрээр мэдэгдэнэ.

2.4.Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь баримт бичгийн бүрдэл бүрдмэгц хүсэлтийг нягтлах ажиллагааг эхлүүлнэ.

Гурав.Хүсэлтийг хянан нягтлах

3.1.Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч, гадаад улсын төрийн шууд болон шууд бус оролцоо, хөрөнгө оруулах салбар, эзэмших хувьцааны хэмжээ, хэлбэрийг нягталж, Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заасан зөвшөөрөл шаардах нөхцөлд хамаарах эсэхийг тогтооно.

3.2.Хэрэв зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээд нь энэхүү журмын 3.1-д заасан зөвшөөрөл шаардах нөхцөлд хамаарахгүй бол энэ тухай хүсэлт гаргагчид бичгээр эсхүл цахим хэлбэрээр мэдэгдэж, хүсэлтийг нягтлах ажиллагааг дуусгавар болгоно.

3.3.Хэрэв зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээд нь энэхүү журмын 3.1-д заасан зөвшөөрөл шаардах нөхцөлд хамаарах бол хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 22.4-т заасан нөхцөл байдал үүсэх эсэхийг нягтална.

3.4.Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 22.4-т заасан нөхцөл байдал үүссэн эсэхийг нягтлахдаа дараах ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

3.4.1.Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 22.5-д заасны дагуу холбогдох байгууллагаас санал, дүгнэлт авах;

3.4.2.Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 22.4.1-д заасан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд харшилсан эсэх талаар Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс /цаашид “Зөвлөл” гэх/ санал, дүгнэлт авах;

3.4.3.холбогдох төрийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг байгуулах.

Дөрөв.Ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажиллах журам

4.1.Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зөвшөөрөл хүсэгчийг энэ журмын 3.1-д заасан зөвшөөрөл шаардах нөхцөлд хамаарна гэж тогтоосноос хойш ажлын таван өдрийн дотор хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хүсэлтийг нягтлах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулж, бүрэлдэхүүнийг батална.

4.2.Ажлын хэсэг дараах бүрэлдэхүүнтэй байна:

4.2.1.дарга - хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн;

4.2.2.гишүүн - санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын холбогдох газрын дарга;

4.2.3.гишүүн - хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын холбогдох газрын дарга;

4.2.4.гишүүн - гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын холбогдох газрын дарга;

4.2.5.гишүүн - тухайн хөрөнгө оруулалтын салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын холбогдох газрын дарга;

4.2.6.гишүүн - шаардлагатай бусад холбогдох төрийн байгууллагын төлөөлөл;

4.2.7.гишүүн бөгөөд нарийн бичгийн дарга - хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга.

4.3.Нарийн бичгийн дарга Ажлын хэсгийн бүрэлдэхүүн батлах тухай шийдвэр гарснаас хойш ажлын хоёр өдрийн дотор шийдвэр болон зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээдийн хүсэлтийг Ажлын хэсгийн гишүүдэд хүргүүлнэ.

4.4.Ажлын хэсгийн гишүүн хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралдаанд оролцох боломжгүй бол төлөөлөн оролцох албан тушаалтны талаар Ажлын хэсгийн нарийн бичгийн даргад урьдчилан бичгээр мэдэгдэнэ.Төлөөлөн оролцож байгаа албан тушаалтан тухайн хуралдаанд Ажлын хэсгийн гишүүний бүрэн эрхийг хэрэгжүүлж, саналын эрхтэй оролцоно.

4.5.Зөвлөлийн Ажлын алба энэ журмын 3.4.2-т заасан хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын санал, дүгнэлт авах хүсэлтийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор үндэсний аюулгүй байдалд харшилсан эсэх санал, дүгнэлтийг Ажлын хэсгийн даргад хүргүүлэх бөгөөд уг хугацаанд ирүүлээгүй бол тусгайлан өгөх саналгүйд тооцно.

4.6.Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга холбогдох байгууллага болон Зөвлөлөөс санал, дүгнэлтийг бүрэн хүлээн авсан, эсхүл Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 22.5-д

заасан хугацаа дууссан өдрөөс хойш ажлын таван өдрийн дотор санал, дүгнэлтийг нэгтгэж, хүсэлтийг нягтлан, дүгнэлтийн төсөл боловсруулж Ажлын хэсгийн даргад хүргүүлнэ.

4.7.Ажлын хэсгийн дарга энэ журмын 4.6-д заасан дүгнэлтийн төслийг хүлээн авснаас хойш ажлын таван өдрийн дотор хуралдааныг зарлан хуралдуулна. Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга дүгнэлтийн төслийг хуралдаанд танилцуулж, Ажлын хэсэг Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 22.4-т заасан нөхцөл байдлын талаарх санал, дүгнэлтийг хэлэлцэнэ.

4.8.Ажлын хэсгийн санал, дүгнэлт нь зөвлөх шинжтэй байх бөгөөд Ажлын хэсгийн нийт гишүүний гуравны хоёроос доошгүй саналаар гаргана. Саналын зөрүүтэй гишүүний санал, үндэслэлийг хуралдааны тэмдэглэлд тусгана.

4.9.Ажлын хэсгийн хэлэлцүүлгийн явцад гарсан санал, дүгнэлтийг хуралдааны тэмдэглэлээр баталгаажуулж, дарга болон нарийн бичгийн дарга гарын үсэг зурна. Тэмдэглэл, холбогдох баримт бичгийг архив, албан хэрэг хөтлөлт болон нууц хамгаалах хууль тогтоомжийн дагуу хадгална.

4.10.Ажлын хэсэг хүсэлтийг хэлэлцэх явцад олж мэдсэн төрийн болон албаны нууц, хүний хувийн мэдээлэл, байгууллагын нууц болон хуулиар хамгаалсан бусад мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хангаж ажиллана.

4.11.Ажлын хэсгийн гишүүн, нарийн бичгийн дарга болон хуралдаанд оролцсон бусад этгээд энэ журмын 4.10-т заасан мэдээллийг зөвхөн хүсэлтийг хэлэлцэн нягтлах зорилгоор ашиглах бөгөөд хуульд заасан үндэслэл, журмаас бусад тохиолдолд бусдад задруулах, дамжуулах, хувилах, нийтэд мэдээлэхийг хориглоно. Нууц хадгалах үүрэг нь тухайн этгээд Ажлын хэсгийн бүрэлдэхүүнээс чөлөөлөгдсөн, эсхүл Ажлын хэсгийн ажиллагаа дуусгавар болсны дараа хуульд заасан хугацаанд хэвээр хадгалагдана.

Тав.Шийдвэр гаргах, мэдэгдэх

5.1.Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Ажлын хэсгийн санал, холбогдох байгууллагын санал, дүгнэлтийг харгалзан хөрөнгө оруулалтын зөвшөөрөл олгох, эсхүл олгохоос татгалзах шийдвэрийг хуульд заасан хугацаанд гаргана.

5.2.Энэхүү журмын 5.1-д заасан шийдвэрийг хүсэлт гаргагчид хуульд заасан хугацаанд бичгээр, эсхүл цахим хэлбэрээр мэдэгдэнэ.

5.3.Зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээд энэхүү журмын 5.1-д заасан шийдвэрийг эс зөвшөөрвөл Монгол Улсын хуульд заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

ХҮСЭЛТИЙН МАЯГТ, АСУУМЖ

Зааварчилгаа: Маягтын бүх хэсгийг монгол хэлээр бөглөж, хамаарахгүй хэсэгт “Хамаарахгүй” гэж тэмдэглэнэ. Хүсэлт гаргагч мэдээллийг үнэн зөв, бүрэн гаргаж, шаардлагатай тайлбар болон нотлох баримтыг хавсаргана.

Нэг. Хүсэлт гаргагчийн мэдээлэл

1.1. Хуулийн этгээдийн нэр, хэлбэр	
1.2. Үүсгэн байгуулагдсан улс	
1.3. Хуулийн этгээдийн бүртгэлийн дугаар, бүртгэсэн огноо	
1.4. Албан ёсны хаяг	
1.5. Үйл ажиллагааны чиглэл	
1.6. Эрх бүхий төлөөлөгчийн нэр, албан тушаал	
1.7. Холбоо барих утас, цахим шуудан	
1.8. Монгол Улс дахь төлөөлөгчийн газар, итгэмжлэгдсэн төлөөлөгч	

Хоёр. Гадаад улсын төрийн өмчлөл, оролцоо болон хяналт

2.1. Гадаад улсын нэр	
2.2. Төрийн өмчлөл, оролцоог хэрэгжүүлэгч байгууллагын нэр	
2.3. Төрийн шууд эзэмшлийн хувь	хувь
2.4. Төрийн шууд бус эзэмшлийн хувь	хувь
2.5. Саналын эрхийн хувь	хувь
2.6. Төрөөс удирдлага томилох, чөлөөлөх, хориг тавих болон бусад хяналт хэрэгжүүлэх эрх	
2.7. Эцсийн өмчлөгч, хяналт хэрэгжүүлэгч этгээд	

Өмчлөл, хяналтын гинжин хэлхээг хүсэлт гаргагчаас гадаад улсын төр хүртэл доорх хүснэгтээр болон бүдүүвч зургаар үзүүлнэ.

№	Хуулийн этгээд/байгууллага	Улс	Шууд эзэмшил %	Шууд бус эзэмшил %	Хяналтын үндэслэл

Гурав. Хөрөнгө оруулалт хүлээн авах Монгол Улсын хуулийн этгээдийн мэдээлэл

3.1. Хуулийн этгээдийн нэр, хэлбэр	
3.2. Хуулийн этгээдийн регистрийн дугаар	
3.3. Хаяг, холбоо барих мэдээлэл	
3.4. Үйл ажиллагааны чиглэл болон тусгай зөвшөөрөлтэй эрхлэх үйл ажиллагаа	
3.5. Хамаарах салбар	☐ Уул уурхай ☐ Банк ☐ Санхүү ☐ Хэвлэл мэдээлэл ☐ Харилцаа холбоо

№	Одоогийн хувьцаа эзэмшигч	Улс	Хувьцаа %	Саналын эрх %

Дөрөв. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 22.4-т заасан нөхцөл байдлын талаарх мэдээлэл

4.1. Хөрөнгө оруулагчийн аливаа үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын шинж чанар нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай холбоотой асуудал үүсгэж болзошгүй эсэх	☐ Тийм ☐ Үгүй ☐ Хамаарахгүй
4.2. Хүсэлт гаргагч Монгол Улсын хууль тогтоомж, бизнесийн тогтсон хэм хэмжээг сахин биелүүлэх нөхцөл, боломжийг хангасан эсэх	☐ Тийм ☐ Үгүй ☐ Хамаарахгүй

4.3. Хөрөнгө оруулалт нь тухайн салбар дахь өрсөлдөөнийг хязгаарлах, давамгайл байдал тогтоох шинжийг агуулсан эсэх	☐ Тийм ☐ Үгүй ☐ Хамаарахгүй
4.4. Хөрөнгө оруулалт нь Монгол Улсын төсвийн орлого, бодлого, үйл ажиллагаанд ноцтой нөлөөлөл үзүүлэх эсэх	☐ Тийм ☐ Үгүй ☐ Хамаарахгүй
4.5. Дээрх асуултын аль нэгэнд “Тийм” гэж хариулсан бол дэлгэрэнгүй тайлбар, эрсдэлийг бууруулах саналаа оруулна уу.	

Тав. Хавсаргасан баримт бичгийн жагсаалт

№	Баримт бичгийн нэр	Хуудасны тоо	Файлын нэр/тайлбар
1	Хуулийн этгээдийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар		
2	Хүсэлт гаргагч, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд болон гүйцэтгэх удирдлагын талаарх бүртгэлийн байгууллагын сүүлийн хоёр жилийн лавлагаа		
3	Урьдчилан тохиролцсон хэлцэл, төрөл, нөхцөл, оролцогч талууд, хувьцааны тоо, хувь, үнэ, хуулийн этгээдийн дүрэм болон удирдлагын өөрчлөлтийн мэдээлэл		
4	Гадаадын төрийн өмчит хуулийн этгээд болон Монголын талын аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулга		
5	Монгол Улсад хийх хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, бизнес төсөл		
6	Өмчлөл, хяналтын гинжин хэлхээний бүдүүвч зураг болон нотлох баримт		
7	Итгэмжлэл, төлөөлөх эрхийг нотлох баримт /хамаарах бол/		
8	Монгол хэлний орчуулга болон баримт бичгийн баталгаажуулалт /хамаарах бол/		
9	Бусад		

Зургаа. Баталгаа

Хүсэлт болон түүнд хавсаргасан баримт бичигт тусгасан мэдээлэл үнэн зөв, бүрэн болохыг баталж байна. Шийдвэр гарах хүртэлх хугацаанд эцсийн өмчлөгч, төрийн оролцоо, хувьцаа эзэмшлийн хэмжээ, хэлцлийн бүтэц болон шийдвэрт нөлөөлөх бусад мэдээлэл өөрчлөгдвөл нэн даруй мэдэгдэх үүрэг хүлээнэ.

Эрх бүхий этгээдийн овог, нэр	
Албан тушаал	

Гарын үсэг, тамга/тэмдэг	
Огноо	_____ оны ____ дугаар сарын ____ -ны өдөр

Гадаадын төрийн өмчит хуулийн этгээдийн хүсэлтийг хүлээн авч,
шийдвэрлэх журмын 2 дугаар хавсралт

**ХҮСЭЛТ, БАРИМТ БИЧГИЙН БҮРДЛИЙГ
ШАЛГАХ ХУУДАС**

Нэг. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 22.1-д заасан баримт бичгийн бүрдэл

№	Баримт бичиг/шаардлага	Бүрэн	Дутуу	Тайлбар
1	Хүсэлт гаргагчийн эрх бүхий бүртгэлийн байгууллагаас олгосон хуулийн этгээдийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар	☐	☐	
2	Хүсэлт гаргагч, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд болон гүйцэтгэх удирдлагын талаарх бүртгэлийн байгууллагын сүүлийн хоёр жилийн лавлагаа	☐	☐	
3	Урьдчилан тохиролцсон хэлцэл, төрөл, нөхцөл, оролцогч талууд, хувьцааны тоо, хувь, үнэ, хуулийн этгээдийн дүрэм болон удирдлагын өөрчлөлтийн мэдээлэл	☐	☐	
4	Гадаадын төрийн өмчит хуулийн этгээд болон Монголын талын аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулга	☐	☐	
5	Монгол Улсад хийх хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, бизнес төсөл	☐	☐	
6	Баримт бичиг монгол хэлээр үйлдэгдсэн, эсхүл монгол хэлний орчуулгатай	☐	☐	
7	Хүсэлтийн маягт, асуумжийг бүрэн бөглөсөн	☐	☐	
8	Төлөөлөх эрхийг нотлох итгэмжлэл, бусад баримт	☐	☐	

Хоёр. Маягт, асуумжийн мэдээллийн бүрэн байдал

№	Шалгах мэдээлэл	Бүрэн	Дутуу	Тайлбар
1	Хүсэлт гаргагчийн бүртгэл, хаяг, холбоо барих мэдээлэл	☐	☐	
2	Гадаад улсын төрийн шууд болон шууд бус өмчлөл, оролцоо, хяналтын мэдээлэл	☐	☐	
3	Эцсийн өмчлөгч, хяналт хэрэгжүүлэгч хүртэлх өмчлөл-хяналтын бүдүүвч зураг	☐	☐	
4	Хөрөнгө оруулалт хүлээн авах Монгол Улсын хуулийн этгээдийн мэдээлэл	☐	☐	
5	Хэлцлийн төрөл, зорилго, үнэ, хувьцаа, саналын эрх болон хяналтын эрх	☐	☐	
6	Хэлцлийн өмнөх болон дараах хувьцаа эзэмшлийн бүтэц	☐	☐	
7	Санхүүжилтийн эх үүсвэр, санхүүжүүлэгч	☐	☐	

№	Шалгах мэдээлэл	Бүрэн	Дутуу	Тайлбар
8	Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, хэрэгжүүлэх хугацаа	☐	☐	
9	Хуулийн 22.4-т заасан нөхцөл байдлын талаарх тайлбар	☐	☐	
10	Эрх бүхий этгээдийн гарын үсэг, баталгаа	☐	☐	

Хүсэлт гаргасан: _____ /Гарын үсгийн тайлал/

Баримт бичгийн бүрдлийг шалгасан ажилтан: _____ /Гарын үсгийн тайлал/

Огноо: _____ оны ____ дугаар сарын ____ -ны өдөр